



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/145

Баян-Овоо

**Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний
цахим дуудлага худалдааг дахин зохион байгуулах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаал, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний цахим дуудлага худалдааг 2024 оны 11 дугаар сарын 06-ны өдрийн 09.00-15.00 цагийн хооронд зохион байгуулсугай.

2. Газруудын зориулалт, хэмжээ, анхны үнэ, дэнчингийн хэмжээ, эзэмшүүлэх хугацаа, дуудлага худалдаа эхлэх цагийн хуваарийг доорхи дурьдсанаар тогтоосугай.

- Баян-Овоо /4-р баг/, Чингисийн тоонот хаалга, орон нутгийн чанартай аялал, жуулчлалын газар байгуулах зориулалттай 5000 м2 газрын анхны үнэ 4.000.000 төгрөг, дэнчингийн хэмжээ 400.000 төгрөг, эзэмшүүлэх хугацаа 60 жил, дуудлага худалдаа 09 цаг 00 минутанд эхлэх,

- Баян-Овоо /4-р баг/ Чингисийн тоонот хаалга зүүн урд, орон нутгийн чанартай аялал, жуулчлалын газар байгуулах зориулалттай 5000 м2 газрын анхны үнэ 4.000.000 төгрөг, дэнчингийн хэмжээ 400.000 төгрөг, эзэмшүүлэх хугацаа 60 жил, дуудлага худалдаа 09 цаг 00 минутанд:

3. Газрын цахим дуудлага худалдааг зохих хууль тогтоомжийн дагуу баримт бичгийг бүрдүүлж зохион байгуулахыг Газрын даамал (Б.Урансайхан)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/145 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХ-ОД

010000379